

Living the Lotus

7
2021

VOL. 190

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн бодрол

Итгэх гэдэг эцсээ хүртэл орхихгүй байх явдал

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 190 (2021.07)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Хүүхэд өсч торниход ямар ч үед итгэж хайрлах хүн дэргэд нь байх шаардлагатай. Ямар ч буруу үйлдэл хийсэн зөвхөн эцэг эх л хүүхэддээ итгэдэг. Тэрхүү агуу их итгэл сэтгэл л хүүхдийн хувьд эцсийн зогсоол, эргэж хөл дээрээ босох шалтгаан нь болдог учиртай.

Сайн хүүхэд болохоор итгэнэ, муу зүйл хийгээд байвал дахиж итгэхгүй гээд байх юм бол үүнийг жинхэнэ итгэл гэж хэлэхгүй. Итгэлийг минь алдаж ч магадгүй гэдгийг давхар бодсоны үндсэн дээр тухайн хүний бурханлаг чанарт бат итгэх нь жинхэнэ итгэл найдвар юм.

Ашид Үл Басагч бодисадвагийн хүндлэн мөргөх үйлийг санаж байна уу? Өөрийг нь цохиж зодож, чулуугаар нүүлгэсэн хүмүүсийн төлөө ч залбирсаар байдаг. Одоо ямар ч муу үйл хийж байсан тэр бол түр зуурын хэрэг бөгөөд удахгүй жинхэнэ мөн чанар нь гарч ирж, гарцаагүй бурханы хутаг олно хэмээн бат итгэдэг болохоор тэгж чадсан.

Хүүхэд эцэг эхийн нүдээр харахад хичнээн муу зүйл хийж байсан ч харах өнцгөө өөрчлөөд үзвэл гарцаагүй ямар нэг сайн тал байдаг. Итгэл найдвар гэдэг ямар ч хүүхэд байсан хэзээ ч орхихгүй байхыг хэлнэ. Яаж ч бохир муу муухайтай хутгалдсан байсан сэтгэлийнх нь гүнд унгаж буй хиргүй тунгалаг сэтгэлийг сэрээж өгөхийн төлөө хичээх нь хүндлэн мөргөл үйл билээ.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X142-143

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд) хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Энэрэхүйн нүд

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

“Энэрэхүйн нүдээр хамаг амьтныг харах” гэдэг нь

“Бүгд амьтнаа энэрэхүйн нүдээр үзмүй. Баясахын далай хязгаарлашгүй амой.” Энэ бол Цагаан Лянхуа судрын “Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвагийн хотол үүдийг өгүүлэх бүлэг”-т гардаг алартай бадаг билээ.

Энэрэхүйн нүдээр хамаг амьтныг харах юм бол хязгааргүй их аз жаргал хуран цуглана гэсэн байна. Тэгвэл энэрэхүйн нүдээр хорвоо ертөнц хийгээд хүмүүсийг харахын тулд юунд анхаарах хэрэгтэй юм бол?

Үүний хариулт гэж хэлж болохоор зүйлийг тус сэтгүүлийн 6-р сарын дугаарт танилцуулсан яруу найрагч Ямао Сансэи гуай “Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва” хэмээх шүлгээрээ илэрхийлж, бурханы сургаалын мөн чанарыг маш ойлгомжтой тайлбарласан байдаг. Бүтээлийнх нь нэг хэсгээс танилцуулья:

Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва гэдэг
Хорвоо ертөнцөөр урсах гүн гүнзгий нигүүлсэл хайрын сэтгэл
Миний дотор урсаж буй гүнзгий энэрэл хайрын сэтгэл билээ
(Товчлов)

Хэн нэгэн хүн надад аз жаргалыг өгвөл
Тэр хүн Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва юм
Нэгэн модны мөчир надад тайтгарал өгвөл
Тэрхүү мөчир эргэлзээгүй Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва юм
(Товчлов)

Би бусдыг буруутгахгүй бол
Би ч гэсэн Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва
Та намайг өршөөн уучилбал
Ариун гэгээн Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва өмнө минь гарч
ирсэн байна гэсэн үг.

Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва гэдэг
Хорвоо ертөнцөөр урсах гүн гүнзгий нигүүлсэл хайрын сэтгэл
Таны ч, миний ч дотор урсаж буй
Нэгэн гүнзгий нигүүлсэхүйн сэтгэл билээ.

Ямар ч хүн ганц уншаад л бурханлаг чанараа мэдрэх гайхамшигт шүлэг гэж бодно.

Өөрийн дотор орших эрхэм нандин зүйлээ ухаараасай гэж хүссэн зохиогчийн нигүүлсэнгүй сэтгэлээс ойлгомжтой үг хэллэгээр сургаалын мөн чанарыг дамжуулья гэсэн билиг ухаан урган гарж уг бүтээл төрсөн буй за.

Энэ шүлгээс аваад үзвэл “Энэрэхүйн нүдээр хамаг амьтныг харах” гэдэг нь ямар ч хүний сэтгэлд Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадватай адил гүн гүнзгий энэрэн нигүүлсэх сэтгэл оршдог гэсэн нүдээр харах гэсэн утгатай болно. Хүн бүр өөр өөрийн амьдралаар амьдарч байгаа хэдий ч, нэгэн бүхэл агуу “Амь”-ын нэг хэсэг бөгөөд тийм эрхэм нандин амь насыг хүртсэн оршихуй гэж харах. Үүнийг хязгааргүй их аз жаргалыг дуудах энэрэхүйн нүд гэж хэлж байгаа юм.

Замыг гэрэлтүүлэгч зул байхын төлөө

Зохиолч Татэмацү Вахэи Точиги муж дахь сүсэг бишрэлийн уул хэмээн олноо хүндлэгдсэн Нангаи ууланд авирсан үеийнхээ сэтгэгдлийг өгүүлэн тэрлэжээ.

Гар чийдэнгүй ууланд авирсан тэр өдөр Татэмацү гуайн хэсэг нөхөд уулнаас оройгож бууснаас болоод нар жаргаж, уулын замаар алхах нэн бэрх болжээ. Алхах замын тэртээ хол Чюүзэнжи нуур байх ба нуурын эргээр бэлэг дурсгалын дэлгүүр, дэн буудлуудын гэрэл гялалзах боловч уулын түнэр харанхуй улам л өтгөрсөөр байв. Тэр үед өмнө талд нь нэгэн бүүдгэр гэрэл үзэгдэв. Тэр нь замдаа ядраад бөгтийн явж байсан эмэгтэйн гар чийдэнгийн өчүүхэн гэрэл байжээ. Татэмацү гуай болон түүний нөхөд эмэгтэйг бараадан явж, ачаанаас нь ч барилцаж өгч. Тийнхүү өчүүхэн жижиг гэрлээр замаа гэрэлтүүлсээр хамтдаа уулнаас буужээ.

Татэмацү гуай ийнхүү тэмдэглэн үлдээжээ: “Ханьсан алхсан бид тэр бүсгүйн хувьд Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва бөгөөд гар чийдэнгээрээ замыг маань гэрэлтүүлж өгсөн тэр бүсгүй бидний хувьд Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва юм. Холын гэрэл хичнээн тод гэрэлтэж байсан ч ямар ч аврал болохгүй. Харин бүүдгэр ч гэсэн яг өмнөх замыг гэрэлтүүлэх гэрлийн ач тус бол агуу юм.” Өчүүхэн жижиг зүйл байж магадгүй ч энэрэн хайрлах, санаа тавих гэсэн бүүдгэр гэрэл дунд л бодисадва оршдог.

Хутагт Мэлмийгээр болгоогч бодисадва хаана ч, хэзээ ч гарч ирж авралын гараа сунгадаг хэмээн сургадаг Хутагт Мэлмийгээр Болгоогч судрын “Хотол Үүдийг нээх” ертөнц гэж үүнийг л хэлнэ. Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх бүлгийн төгсгөлд энэрэн нигүүлсэх сэтгэлийн хязгаарыг илэрхийлсэн дараах мөр байдаг:

“Яаж эдгээр амьтан нугуудыг номын замд оруулж, Ялж төгс нөгчсөний ариун хутгийг олуулах буй хэмээн би бээр ямагт сэтгэлдээ бясалгамой.” Энэ бадгийг бид өөрийн хүсэл зорилгоо болгож, бусдын сайн сайхны төлөө сэтгэлтэй байх аваас тэнд олон олон бодисадва нар төрөн гарч ирж, бүгд аз жаргалтай болох юм шүү хэмээн Хутагт Мэлмийгээр Болгоогч судар бидэнд урам зориг, аз жаргалыг өгдөг билээ.

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Хотолд Сайн бодисадвагийн явдлыг үзэхүй ном хэмээх судар

Энэхүү судар бол “Гайхамшигт ном Цагаан Лянхуа Судар”-ын төгсгөлийн “Хотолд Сайн бодисадвагийн зоригжуулсныг өгүүлэх 28 дугаар бүлэг”-ийн үргэлжлэл бөгөөд Хотолд Сайн бодисадвагийн талаар илүү дэлгэрэнгүй айлдсан байдаг. Дээдийн наминчлалын тухай айлдсан сургаал учраас өөрөөр “Наминчлах судар” гэж нэрлэдэг.

Хотолд Сайн бодисадваг үзэхүй

Бүлгийн нэр болох “Хотолд Сайн бодисадваг олж харах үйл” гэдэг нь Хотолд Сайн бодисадвагийн үйлийн ач буяныг сайтар олж харснаар тэрхүү сэтгэлтэй өөрийн сэтгэл зүрх нэгэн цул болж, оюун санаа бурханы зам мөрд шулуудаж, улмаар Хотол Сайн бодисадвагийн үйлийг хийж чаддаг болох гэсэн бурханы үйлийг хэрэгжүүлэх арга барил гэсэн утгатай.

Уг бүлэгт “Хотолд Сайн бодисадвагийн биеийг үзэх” гэдэг зүйл хэдэнтээ давтагдан гарах бөгөөд тэр нь өөрийн зүрх сэтгэл Хотолд Сайн бодисадвагийн сэтгэлтэй яв цав тохирох гэсэн утгыг илэрхийлж буйгаас өөрцгүй. Хэрэв тэр мэт хязгаарт хүрээгүй байгаа бол зам мөрд тань юу дутагдаад буйг эргэцүүлэн тунгааж, наминчлах шаардлага байна гэсэн үг.

Мөн Хотолд Сайн бодисадвагийн биеийг үзэж чадсан ч түүндээ сэтгэл ханалгүй цаашид “Бурханы биеийг үзэх”-ийн төлөө хичээн зүтгэх ёстой болохыг айлдан сургажээ. Өөрийн сэтгэл Бурханы сэтгэл зүрхтэй нэгэн бүхэл болж байж гэмээнэ бурханы зам мөрд шамдах үйл төгс болох учиртай.

Дээдийн наминчлал бол жинхэнэ дүр төрхийг тунгаан бодох явдал

Сударт “Хамгийн дээдийн наминчлал бол юмсын жинхэнэ дүр төрхийг тунгаан бодох явдал” хэмээн сургасан. Юмсын жинхэнэ дүр төрх гэдэг нь нэгдүгээрт хоосон чанар болно. Зургаан мэдрэхүйн нүглээ наминчилж, үүнийгээ нэгэн сэтгэлээр бясалган бүрэн ухаарч чадвал Бурханы сэтгэлтэй нэгэн бүхэл болж чадах бөгөөд нүгэл хилэнц нарны гэрэл шүүдэр мананг сарниулах мэт агуу билгэ бэлгийн гэрэл нүгэл хилэнцээс ангижруулах болно хэмээн сургажээ.



Эгэл жирийн хүн наминчлах үйлийг хэрэгжүүлэх нь

Эцэст нь Бурхан багш эгэл хүмүүн, ялангуяа зүрх сэтгэлт хүмүүс хэрхэн наминчлахыг бодитоор зааж өгсөн.

Нэгдүгээрт гурван эрдэнийг хүндлэн дээдэлж, лам, хуврагын сүсэг бишрэлийн зам мөрд саад болохгүй байж, сэтгэлийн зургаан сургаал (Бурхан, сургаал, лам, сахил, өргөл, тэнгэр)-ыг хэрэгжүүлж, Их хөлгөний сургаалыг баримтлагч хүмүүнийг эрхэмлэн дээдэлж, хэзээд “Хоосон чанар (юмсын жинхэнэ дүр төрх)” гэдгийг сэтгэлдээ санаж явах.

Хоёрдугаарт эцэг эхээ халамжилж, багш, ахмад хүмүүсийг хүндлэх.

Гуравдугаарт зөв сургаалд тулгуурлан улс орноо удирдан залж, андуу ташаа бодлоор ард иргэдээ буруу замд оруулахгүй байх. (Улс төрч хүн эв нэгдлийг эрхэмлэн зөв аргаар улсаа удирдах. Эсвэл байгууллага зэргийг удирдагч хүн хүмүүсийг зөв удирдах)

Дөрөвдүгээрт сард 6 удаа тохиодог бурханы зам мөрд хичээн шамдах өдөр өөрийн захирч буй газар нутагтаа (нөлөөлж чадах хүрээндээ) уриалга гаргаж, удирдан захирах хүчийнхээ хүрээнд аливаа амьд амьтан бүхнийг хайрлан дээдэлж байхыг уриалан дуудах.

Тавдугаарт учир шалтгааны хуулинд гүнээ итгэж, бурханы гэгээрэлд хүрэх бодисадвагийн зам мөрд итгэн, Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Бурхан Будда үргэлж хамт байж, хэзээ ч устаж үгүй болохгүй гэдгийг ухаарах явдал юм.





Бурханы сургаалыг нэгтгэн дүгнэх нь

Дээрх таван зүйлийн наминчлалыг хэрэгжүүлэх нь өнөөгийн ардчилсан нийгэмд хүн нэг бүрийн хэрэгжүүлбэл зохих эрхэм чухал зүйлс билээ. Ялангуяа тав дугаарх “Учир шалтгааны хууль, жинхэнэ зам мөрд гүнээ итгэж, Бурхан хэзээ ч устаж үгүй болохгүйг мэдэх ёстой” гэсэн энэ л үг Бурханы сургаалыг бүхэлд нь нэгтгэн дүгнэсэн, жинхэнэ эрхэм сургаал болохыг хэлэхгүй байх аргагүй.

“Учир шалтгаан” гэдэг нөхцөл шалтгаан, үйлийн үрийн тухай ертөнцийн хууль бөгөөд “Шүтэн барилдлагын хууль”, “Үйлийн үрийн сургаал” ч гэж хэлдэг бурханы сургаалын үндсэн сургаал юм.


“Ганцхан зам мөр” гэдэг нь гагцхүү жинхэнэ үнэний зам, Бурхан болох зам, бодисадвагийн зам мөрийг хэлнэ. Бурханы сургаал олон янз байдаг ч гэсэн бүгд адил хамаг амьтадыг “Бурханы түвшинд хүргэх” гэсэн цорын ганц зорилготой байдаг гэсэн үг. Энэ бол “Жинхэнэ үнэний зам мөр” юм.

“Бурхан хэзээ ч устаж үгүй болохгүйг ухаарч мэдэх” гэдэг нь мэдээж хэрэг Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Бурхан Будда үхэшгүй мөнх бөгөөд бид бүхэн түүний ачаар амьдарч буй жинхэнэ үнэнийг ухаарах явдал юм.

Энэ гуравт чин сэтгэлээсээ бат итгэсэн ямар ч хүн жинхэнэ оюун санааны эрх чөлөөний хязгаарт хүрэх болно. Энэ бол жинхэнэ аз жаргал билээ. Энэ үг үнэхээр Лянхуан Гурамсан Судрын сүүлийг мушгихад тохиромжтой агуу үг билээ.

«Лянхуан Гурамсан Сударын бүлэр тус бүрийн тайлбар»,
Нивано Никкёо, Косей хэвлэлийн компани, 1991 он





Олон улсын хэлтсийн даргын булан

Хүнтэй харилцахдаа гаргуун хүн


Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа ч гэсэн “Хутагт Мэлмийгээр болгоогч судар”-аас өгүүлсэн нь “Энэрэхүйн нүдтэй байх”-ыг ямар их чухалд үзэж байгаа нь харагдана. Ерөнхийдөгч “Хүн бүхний дотор хязгааргүй их зол жаргалыг дуудах энэрэхүй сэтгэл урсаж байдгийг санаж, өдөр бүрийг бусдын төлөө гэсэн сайхан сэтгээр өнгөрүүлцгээе” гэж хэлж байх шиг.

Энэ үг “Хүнтэй харилцахдаа гаргуун болох нь Лянхуа судрыг хэрэгжүүлж байгаагаас өөрцгүй” гэж ойлгомжтой сургасан Үүсгэн байгуулагчийн үгийг санагдуулж байна. Сүүлийн үед Нивано ерөнхийлөгч, Коошоо багштан нар “хүнтэй учрах арга барилаа сайжруулах” талаар бидэнд шууд бусаар хэлж сургаад байх шиг санагдана.

Орон даяарх салбарын тэргүүнүүдийн онлайн зөвөлгөөний үеэр салбарынх нь ойн баяр тохиож буй тэргүүнүүдээс “Ойн баяр тэмдэглэх боломж байна гэдэг талархмаар зүйл юм байна гэж бодогдож байна уу” гэж олонтой асуусан гэж дуулсан. Корона вирус тархсанаас болоод ойн баярын арга хэмжээг хүссэнээрээ хийх боломжгүй нөхцөл байдалтай байгаа. Ерөнхийлөгчийн асуултын цаад санаа нь ойн баярыг хүсэн хүлээх гишүүдийн харамсах сэтгэлийг салбарын тэргүүн нар үнэн сэтгэлээсээ ойлгож хүлээж авах чухал гэдгийг сургасан болов уу. Түүнчлэн бидний доторх “энэрэнгүй нүд”-д бат итгэж байгаагийн илрэл гэж бодож байна. Би энэ үйл явдлын талаар сонссоныхоо хувьд өдөр тутамдаа уулзан учрах хүмүүсийн нөхцөл байдлыг ойлгож, санаа тавьж харилцдаг болохын төлөө хичээх болно.



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: info@rkina.org
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

Korean Rissho Kosei-kai of Busan
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

Rissho Kosei-kai Ramu

Rissho Kosei-kai Aburkhill

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>